

М. З у л ь к а ф и л ь

ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙ БА ТҮҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ОРЧИН

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй. Энэ бол ардчилсан нийгэм байгуулах явцад бидний үгийн санд чөлөөт хэвлэл, хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт сэтгүүлч, ил тод байдал, олон ургальч үзэл зэрэг нэр томъёоны хамт орж ирсэн шинэ зүйл юм. Учир нь 1990-ээд оноос өмнө Монголд ардчилал, чөлөөт хэвлэл байгаагүйн нэгэн адил эрэн сурвалжлах сэтгүүл зүй хэмээх нэр томъёо байгаагүй. Энэ бол сэтгүүл зүйн практикт шинээр орж ирсэн цоо шинэ үзэгдэл байсан бөгөөд үүнд шинээр суралцах шаардлага хурцаар тавигдсан билээ. Чөлөөт хэвлэлийг авч явах, тэр тусмаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хэвшүүлэхэд бэлэн, туршлагатай боловсон хүчингүй манай орны хувьд бүр ч хэцүү байсан нь ойлгомжтой. Нөгөө талаар өндөр хөгжилтэй ардчилсан орнуудад ч эрэн сурвалжлах сэтгүүл зүй жинхэнэ утгаараа хөгжиж нэг их удаагүй байгааг хэлэх хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан бяцхан түүх өгүүлье.

АНУ-ын алдарт “Вашингтон пост” сонины уулзалтын өрөөний хойморт сониныхоо нэгэн дугаарын тугалган хэвийг байрлуулсан байдаг. Энэ бол сонины анхны ч, ямар нэгэн түүхт ой, баяр ёслолтой холбоотой гарсан дугаар ч бус харин зөвхөн Америкийн төдийгүй дэлхий дахины сэтгүүл зүйн түүхэнд шинэ мөрнөөс бичигдсэн нэгэн томоохон үйл явдалтай холбоотой ажээ.

1970-аад оны үед АНУ-ын Ерөнхийлөгч Ричард М. Никсон сөрөг хүчнийхээ чагнах хэрэгслийн тусламжтайгаар тагнаж байсан нь илчлэгдэж огцорсон билээ. Түүнийг анх илрүүлсэн хүмүүс нь сэтгүүлчид байсан бөгөөд хожим сэтгүүл зүйн түүхэнд алтан үсгээр бичигдэн үлджээ. Чухам энэ үеэс сэтгүүл зүй нэгдсэн улсын Ерөнхийлөгчийг хүртэл огцруулж болдгийг олон түмэн мэдсэн юм.

“Вашингтон пост” сонины хананд буй тугалган хэв бол Ерөнхийлөгч Ричард М. Никсон Уотергейтээс болж огцорсон тухай сурвалжлага нийтлэгдсэн тэр дугаарынх ажээ. Энэ сонины ажилтнууд уг тагнасан чагнасан хэргийг эрэн сурвалжилж, тодруулж, хөдлөшгүй баримтаар нотолж чадсан бөгөөд тэднийг АНУ-д эрэн сурвалжлах сэтгүүл зүйн загалмайлсан эцэг хэмээн нэрлэдэг байна.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тухай яриа хөөрөө гол төлөв эндээс эхэлдэг бөгөөд сэтгүүлчид гэж янз бүрийн мэдээ, материал бичдэг уужуу тайван хүмүүс бус мэргэжлийн мөрдөгчид, тагнуулуудаас дутахгүй ажиллаж мэдээлэл олдог шуурхай, овсгоо самбаатай хүмүүсийг нэрлэдэг юм байна гэдэг ойлголт төлөвшиж эхэлжээ. Тиймээс Америкийн сэтгүүлчдийн “Тагнуулын төв газраас түрүүлж мэдэх ёстой” гэдэг уриа ч үүнээс үүдэлтэй юм. Үүнийг Америкийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн шилдэг жишээ төдийгүй, эрэн

сурвалжлах сэтгүүл зүйг улам идэвхтэй хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн үйл явдал гэж үздэг. Америкт үүнээс өмнө тодорхой амжилтанд хүрч байсан эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон жишээ, баримт байсан боловч Ерөнхийлөгчийг хүртэл огцруулах тийм төвшинд хараахан хүрч чадаагүй байв. Бас ийм жишээ дэлхийн өөр улс оронд ч нэн ховор юм. Гэхдээ Америкийн сэтгүүл зүй ийм амжилтын оргилд 200-аад жилийн урт замыг туулж, багагүй саад бэрхшээлтэй тулгарч, чөлөөт сэтгүүл зүйг жинхэнэ утгаараа төлөвшүүлэхийн төлөө уйгагүй тэмцэж байж хүрч чадсан билээ. Үүнтэй харьцуулахад манай чөлөөт хэвлэл дөнгөж эхлэл төдий байгаа нь тодорхой юм. Чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх нөхцөл боломж, эрх зүйн орчин дөнгөж бүрэлдэж эхэлсэн бөгөөд түүний салшгүй хэсэг болсон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн зарим шинж тэмдэг, анхны оролдлого л илрэх төдий байгаа гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй.

Тэгвэл эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэж юу вэ?

Бидний "эрэн сурвалжлах сэтгүүл зүй" гэж нэрлэдэг энэхүү нэр томъёог англи хэлтэй орнуудад **"Investigative journalism"**, орос хэлэнд "журналистское расследование" гэж нэрлэдэг. Харин оросууд "сэтгүүлчийн эрэн сурвалжлах ажиллагаа" гэж илүү оновчтой орчуулсан мэт санагддаг. Манайд аливаа асуудлын дотоод мөн чанарт нь нэвтрэн ороогүй, түүний шалтгаан үр дагаварыг дэлгэн үзүүлээгүй, дэвшүүлэн тавьсан санаа, өгч буй үнэлэлт дүгнэлтийг хөдлөшгүй баримт сэлтээр нотолж чадаагүй, далд бугшмал булхай, хуйвалдааны шинжтэй зүйлийг олон нийтэд ил тод гаргаж тавиагүй, үүнийг батлах хангалттай баримт цуглуулаагүй, үзэгдлийг гадна талаас нь өнгөцхөн шүүмжилсэн, асуудлыг тодруулах төдий хэдэн баримтад түшиглэсэн нийтлэлийг "эрэн сурвалжлах сэтгүүл зүй" гэж нэрлэдэг нь түгээмэл юм. Нөгөө талаар өдөр тутам гарч байдаг гэмт хэргийн сурвалжлага, хоёр хүний хоорондох хэрүүл маргааны шинжтэй нийтлэл, бусдыг санаатай гүтгэн гүжирдсэн ярилцлага, банкны ажлын тайлан төдий зүйл, мөрдөн байцаагч, эсвэл шүүгчийн ажил төрлийн талаарх танилцуулга мэт зүйлийг ч эрэн сурвалжлах сэтгүүл зүйтэй хольж хутгах тохиолдол ч бий. Түүнчлэн мөрдөн шалгах үйл явц дуусаагүй байхад гэмт хэрэгтнийг өмөөрөх өнгө аястай, худал үнэн нь батлагдаж нотлогдоогүй баримтуудыг шүүрэн авч сэтгэлийн хөдөлгөөнөөр мэдээлж, олон түмнийг төөрөлдүүлэх уур амьсгал бий болгохуйц сурвалжлага бэлтгэж, хэмжээнээс хэтэрсэн том том дүгнэлт хийх явдал манай эрэн сурвалжлагчдын үйл ажиллагаанд оршиж буй томоохон дутагдлын нэг юм.

Ер нь радио, телевизийн мэдээллийн нэвтрүүлгээр цацаж байгаа шуурхай сурвалжлага эрэн сурвалжлах сэтгүүл зүй хоёр газар тэнгэр хоёр шиг эрс өөр зүйл гэдгийг манай зарим сэтгүүлчид хараахан ойлгоогүй байгаа нь ажиглагддаг. Энэ бүхэн нь манай сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэдэг нь харьцангуй шинэ зүйл, үүнд суралцах шаардлагатай, тодорхой дадлага, чадвар, мэдлэг эзэмших хэрэгтэй гэдгийг харуулж байгаа баримт юм.

Олон түмэнд ил, мэдээжийн зүйл хэзээ ч эрэн сурвалжлах сэтгүүл зүйн объект болж чадахгүй. Тиймээс Өрнөдийн судлаачид "тодорхой хувь хүн болон байгууллага бусдаас ямагт нууцалж байдаг тэр зүйлийн гүнд нь нэвтэрч, тэгснээрээ нийгмийн эрх ашгийг хөндсөн чухал асуудлыг дэлгэж тавьсан нийтлэл, нэвтрүүлгийг эрэн сурвалжлах сэтгүүл зүй"¹ гэж үздэг байна. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нийтлэл, нэвтрүүлгийн сэдэв нь:

- а. Олон түмний эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;
- б. Нийгмийн ач холбогдол өндөр, хүлээн авагчдын сэтгэхүйд нөлөөлөх чадвар сайтай байх;
- в. Сэтгүүлчийн тусгаж буй баримтыг хувь хүн, байгууллага олон нийтээс нуухыг эрмэлзэж байх гэсэн гурван гол хүчин зүйлийг өөртөө агуулах онцлогтой.

Дээрх хүчин зүйлүүдийн аль нэгийг агуулаагүй нөхцөлд тухайн баримт эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сэдэв болох боломжгүй. Манай сэтгүүлчдийн эрэн сурвалжлах үйл ажиллагаанд оршиж буй нэг гол дутагдал нь энэхүү хүчин зүйлүүдийг бүрэн харгалзан үзэж чадахгүй байгаа явдал юм. Тиймээс тодорхой үр дүнд хүрэхгүй замын дунд алга болох, эхлэл нь амжилттай боловч сэдэв, чиглэлийг тууштай баримталж, шаргуу хөөцөлдөж чадаагүйн улмаас ямар ч үр дүн төгсгөлгүй үлдэх, баримтад гүнзгий дүн шинжилгээ хийх аналитик сэтгэлгээ, логик сэтгэмж дутсанаас гол чиг шугамаа алдаж өөр голдирол руу гулсан орох тохиолдол ч цөөнгүй гардаг. Энэ бол эрэн сурвалжлах ажлын дадлага, туршлага, ур чадвар дутаж байгаатай холбоотой юм.

Ардчиллын нэг тулгур зарчим нь сонгогдсон төлөөлөгчид болон төрийн албан хаагчид ард түмний өмнө хариуцлага хүлээх зарчим мөн. Хариуцлага хүлээх олон төрлийн механизмыг бий болгох нь хамгийн тохиромжтой боловч хамгийн төгс тогтолцоог урвуулан ашиглах явдал гарч болзошгүй. Алдаа завхрал гарвал түүнийг илчилж, засаж залруулахад эрэн сурвалжлах сэтгүүл зүй гол үүрэгтэй гэдгийг Барууны сэтгүүл зүйн туршлага харуулж байна.

Тиймээс "төр засгийн үйл ажиллагаа, түүний дотор авилгал, төрийн эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах явдлыг олон нийт сонирхдог учраас олон нийтийн хэвлэл мэдээллийн гүйцэтгэх "хоточ нохойн" үүргийн ач холбогдлыг"² Хүний эрхийн Европын шүүх онцлон тэмдэглэсэн байдаг.

Энэ утгаар авч үзвэл эрэн сурвалжлах сэтгүүл зүй чөлөөт хэвлэлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нийгэмд эрүүл саруул уур амьсгал бий болох замаар үнэнийг олох, олон түмний санаа бодолд тулгуурлан төр засаг, аливаа удирдах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавихад ихээхэн чухал үүрэгтэй гэдэг нь тодорхой байна. Энэ үүргийг үйл ажиллагааны дараах чиглэлээр практикт хэрэгжүүлэх боломжтой юм. Үүнд:

¹ Уллмен Дж. Журналистские расследования: современные методы и техника. М. 1998. С. 17.

² Мендель Т. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба эрэн сурвалжлах сэтгүүл зүй (лекц). УБ. МХХ. 1998.

- Далд, олон нийтийн хараа хяналтаас нуугдмал байгаа хуйвалдаан, мафийн шинжтэй үйл явдлыг хөдлөшгүй баримтаар ил гаргаж тавих, олон түмний анхаарлыг үүнд нэн даруй хандуулах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн “дөрөв дэх засаглалын” үүрэг, ач холбогдол нь ихэнх тохиолдолд гагцхүү эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр дамжин илэрдэг. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалын алдаа завхрал, үйл ажиллагаанд оршиж буй ноцтой дутагдлыг олон түмэнд дэлгэн харуулах замаар хяналт тавих боломж гагцхүү чөлөөт хэвлэлд байдаг. Үүнийг эрэн сурвалжлах сэтгүүл зүй хийж чаддаг учраас бусад төрлийн нийтлэл, нэвтрүүлгээс ихээхэн давуу талтай юм. Тиймээс дээрх гурван засаглалын үйл ажиллагааг юуны өмнө анхаарлын төвд байлгах;
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн баримтлах гол зарчим нь ил тод байх, олон ургальч шинжтэй байх явдал бөгөөд үүний үндсэн дээр бүх зүйлийг ард түмний хараа хяналтанд байлгах, албан тушаалын гэмт хэрэг, төр засгийн хүчирхийллийн механизм, аливаа төсөл, тендерийн цаадах хуйвалдаан зэргийг илчилж, олон нийтийн сонорт хүргэх.
- Улс орны үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц үйлдлийг илчилж, зогсооход нийтлэл, нэвтрүүлгээ чиглүүлэх. Үүнийг улс төр, бизнес, хуулийн байгууллагын далд дам сүлжээнд холбогдсон мафийн шинжтэй хуулийн байгууллага илчилж чадахгүй, гагцхүү эрэн сурвалжлах ажлыг өндөр түвшинд эзэмшсэн сэтгүүлчид илчилж, таслан зогсоож чадах юм.
- Аливаа оронд шударга, хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах нь чөлөөт хэвлэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжил, түүнийг бүх талаар дэмжих, хамтран ажиллах үйл явцаас ихээхэн шалтгаалах учраас мэргэшсэн эрэн сурвалжлагчдыг бэлтгэх шаардлагатай. Эрэн сурвалжлагч мэргэжлийн хувьд маш сайн сэтгүүлч байхаас гадна хөдөлмөрч, ажил хэрэгч, тэсвэр хатуужилтай, авхаалжтай, зоригтой, бас хууль, эдийн засаг болон өөрийн мэргэшсэн салбарын талаар гүнзгий мэдлэгтэй байх учиртай юм.

Тухайн оронд эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхийн тулд юуны өмнө таатай орчин бүрдсэн байх ёстой. Ийм орчин бүрдээгүй нөхцөлд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тухай ярих боломжгүй юм. Тийм таатай орчин бүрдүүлэхэд нэн түрүүнд дараах гурван хүчин зүйл нөлөөлөх болно. Үүнд:

Нэгдүгээрт: эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлж чадахуйц бие даасан, олон ургальч үзлийн индэр болсон хэвлэл мэдээллийн хэрэгсэл байх шаардлагатай. Өнөөдөр манай оронд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн 1207 хэвлэл мэдээллийн хэрэгслийн 95 хувь нь төрийн бус бие даасан мэдээллийн хэрэгсэл юм. Тэдний дотор эрэн сурвалжлах албатай, энэ чиглэлийг түлхүү барьж ажилладаг хэд хэдэн томоохон сонин бий. Нөгөө

талаар гэмт хэргийн асуудлыг дагнан тусгадаг төрөлжсөн сонин хэвлэл ч гарч байна. Бас сэтгүүлчдийн аливаа ноцтой мэдээллийг олж авах, эрж хайх, эцэст нь хүртэл хөөцөлдөх идэвх санаачилга нь дээшилж, манай хэвлэл мэдээллийн хэрэгсэлд идэвхтэй мэдээллийн тоо тэр хэмжээгээрээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Энэ бүхэн нь эрэн сурвалжлах сэтгүүл зүй оршин тогтох, цаашид хөгжих нөхцөл боломж нь бүрдэж эхэлсний илрэл юм.

Хоёрдугаарт: сэтгүүлчид асуудлыг зөв тогтоож, түүнийг тал бүрээс нь судалж, мөрдөж чадах дадал, чадвар эзэмшсэн байх шаардлагатай. Энэ бол сэтгүүлч олон эх сурвалжаас нэн чухал, хамгийн гол мэдээллийг олж чадах, түүнийг зөв, оновчтой ашиглах арга барилд суралцаж, тодорхой туршлага хуримтлуулсан байх ёстой юм. Үүнийг зохих түвшинд эзэмшээгүй нөхцөлд эрэн сурвалжлагыг амжилттай хийх боломжгүй. Манай эрэн сурвалжлагчид үүнд дөнгөж суралцаж эхэлж байгаа бөгөөд цаашид олон зүйлийг эзэмших, улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Гуравдугаарт: үнэхээр олон түмний, нийгмийн ашиг сонирхолд нийцсэн асуудлыг хөндсөн нийтлэлийг ямар нэгэн хяналтад (цензурт) орж, буруутгаж, яллагдана гэж айж эмээхгүйгээр чөлөөтэй хэвлэн нийтлэх, радио телевизээр дамжуулах эрхтэй байх хэрэгтэй.

Дээрх гурван нөхцөл, хүчин зүйлийг нарийн тунгаан үзэж, өнөөгийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн явц, практик алхмуудыг ажиглахад ерөөсөө эрэн сурвалжлах сэтгүүл зүйн оршин тогтнох гол эх суурь нь чөлөөт, бие даасан хэвлэлийн тогтолцоо юм. Өнөөдөр манай оронд чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх таатай орчин бүрдэж эхэлсэн нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг төлөвшүүлэх боломжийг бий болгосон юм.

Үүнд юуны өмнө хоёр гол хүчин зүйл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь Хэвлэлийг хянах газрыг татан буулгаж, цензурыг устгасан болон "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуулийг УИХ-аас батлан гаргасан явдал юм. Үүний үр дүнд чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчин бий болох томоохон алхам хийгдсэн.

Ард түмэн төрөө хянах цорын ганц бололцоо нь мэдээллийн хэрэгсэл чөлөөт байх явдал юм. Нийгэм эрүүл саруул, шударга ёс төлөвшихөд нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйл чөлөөт хэвлэл, түүний дотор эрэн сурвалжлах сэтгүүл зүй байдаг. Энэхүү эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх гол нөхцөл бол түүнд тохирсон эрх зүйн орчин, хүрээг бий болгох явдал юм. Мэдээж ийм нөхцлийг маш богино хугацаанд, нэг л өдрийн дотор бүрдүүлэх боломжгүй бөгөөд алхам алхамаар, янз бүрийн үе шатанд өргөн цар хүрээтэй, шургуу үйл ажиллагаа явуулах явцад бий болох онцлогтой.

Дэлхий дахины сэтгүүл зүйн практикаас үзэхэд эрэн сурвалжлах сэтгүүл зүйг амжилттай хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлдэг гурван үндсэн хүчин зүйл байдаг бөгөөд энэ нь бидний дээр дурьдсан үндсэн гурван хүчин зүйлтэй яв цав дүйдэг ажээ. Үүнд:

1. Хэвлэл мэдээллийг зохицуулсан таатай бүтэц, өөрөөр хэлбэл тухайн оронд ОНМХ-ийн оновчтой систем үйлчилдэг байх ёстой. Энэ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг гол болгодог бие даасан, олон ургальч үзэл дээр тулгуурласан хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөгжүүлэх болон сэтгүүлчийн мэргэжлийг саадгүй эзэмших, түүний аль нэг чиглэлээр нарийн мэргэших бололцоогоор хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийм боломж, нөхцөл бүрдээгүй тохиолдолд мафийн сүлжээ, авилгал, албан тушаал, эрх мэдлийг хэтрүүлэн ашиглах, хээл хахууль авах, хариуцлага тооцох зэрэг асуудлыг мөрдөж судлах, ил гаргаж ирэх сонирхол сэтгүүлчид төрөхгүй болно.

2. Мэдээлэл хүлээж авах, түгээх чөлөөтэй тогтолцоо байх ёстой. Ийм тогтолцоо баймааж л авилгалтай холбоотой мэдээллийг сэтгүүлчид ухаж түнхэж, нарийвчлан судалж олох боломжтой төдийгүй, ул үндэсгүй мэдээлэл тараасан гэж шүүхэд дуудагдахад хүрвэл өөрийгөө хамгаалж чадна. Нөгөө талаар энэ нь мэдээллийн эх сурвалжид чөлөөтэй нэвтрэх, олж авсан мэдээллийг чөлөөтэй ашиглах боломжоор хангана. Тиймээс энэ хүчин зүйлийг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн амин сүнс гэж нэрлэдэг.

3. Хэвлэн нийтлэх эрхийг хязгаарласан цөөн тооны хязгаарлалт гэж бий. Цензур, нэр төр гутаасны төлөө хатуу шийтгэл оноодог хууль тогтоомж зэргээр хэвлэн нийтлэх эрх чөлөөг хавчин хязгаарлах нь авилгалын хэргийг илчилсэн ч түүнийг хэвлэн нийтэлж чадахгүйд хүрнэ. Өөрөөр хэлбэл, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарладаг нийтлэл нь талаар өнгөрөх тохиолдол цөөнгүй гардаг учраас айж эмээх, болгоомжлох, урам хугарах, өмнөө тавьсан зорилгоосоо ухрах явдал ч гардаг. Манай орны янз бүрийн хууль тогтоомжид ийм заалт цөөнгүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Энэ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжихөд маш их саад бэрхшээл учруулж, чөдөр тушаа болдог. Ялангуяа манай орны Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад эрх зүйн актуудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хаасан, боосон, замыг нь тасалсан заалтууд нэлээд байна. Тухайлбал, мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулсан бол хэдэн жилийн ял өгөх, мөрдөн байцаах ажиллагаанаас тодорхой мэдээллийг аваад олон түмэнд цацвал ямар нэгэн шийтгэл торгууль оногдуулна гэсэн заалтууд бий. Гэтэл эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэдэг маань тийм нуугдмал юмыг олон түмэнд ил гаргаж, мэдээллийг бодит утгаар нь хүргэх учиртай юм.

Нэг жишээ дурдахад авилгалын хэрэгт холбогдсон УИХ-ын гурван гишүүний хэргийг хянасан прокурорын яллах дүгнэлтийг "Сэрүүлэг" сонины сэтгүүлчид их хөдөлмөр гаргаж, хүнд нөхцөлд ажиллаж байж олж, сониндоо нийтэлсний төлөө ихээхэн дарамт шахалтанд орсон байв. Энэхүү ганц жишээ манай оронд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хэчнээн хүнд, ээдрээтэй нөхцөлд байгааг харуулж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүхий л төрөл, түүний дотор электрон мэдээллийн хэрэгслийн аль аль нь бие даасан байдалтай, ОНМХ-ийн хэв маяг, төрөл хэлбэр олон янз байхгүй бол эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих

боломжгүй гэж үздэг. Энд хоёр зүйл маш хүчтэй нөлөөлдөг. Нэг дэх нь олон түмэн өөрөө ОНМХ-ийн бие даасан байдлыг хүндэтгэн дэмжиж, аль болохоор туслах явдал бол, хоёр дахь нь чөлөөт бие даасан хэвлэл мэдээлэл идэвхтэй хөгжиж чадахуйц орчныг төр засаг бий болгох явдал юм. Тиймээс Европын орнуудад энэ хоёр асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн анхаардаг. Үүний тодорхой нэг жишээ бол Европын холбооны Сайд нарын хороо ОНМХ-үүдийн бие даасан байдлыг хангахад чиглэгдсэн хэд хэдэн үндсэн чиглэлийг боловсруулсан явдал мөн. Үүнд:

а. Нийгмийн тодорхой институт болох ОНМХ-ийн автономит байдлыг, бас редакцийн өгүүллийн бие даасан байдлыг хүлээн зөвшөөрсөн хатуу баталгаа гаргажээ. Өөрөөр хэлбэл, бие даасан болон олон нийтийн ХМХ-ийн хөтөлбөрийн цаг, мэдээ дамжуулах хэлбэр, санхүүг зарцуулах боловсон хүчнийг сонгох эрх зэрэг асуудлууд үүнд багтсан юм.

б. Бүх төрлийн цензурыг хориглох,

в. Удирдах зөвлөлийн гишүүдийг ил тод олон ургальч үзлийн үндсэн дээр томилдог байхаас гадна нийгмийг бүхэлд нь төлөөлж чадахуйц төлөөлөлтэй байх зэрэг зарчмууд оржээ.

Эдгээр удирдамж нь ОНМХ-ийн бие даасан байдал болон төлөөллийн ач холбогдлыг тодорхойлж, үйл ажиллагааны баримтлах гол чиглэлийг зааж өгснөөрөө чухал юм.

Хүний эрхийн Европын шүүх 1999 онд мэдээлэл дамжуулах байгууллагад болон ОНМХ-ийн үйл ажиллагаанд олон нийтийн монополь тогтоох нь Хүний эрхийн тухай Европын конвенцийн заалт болох санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг хязгаарлаж байгаа эсэхийг авч хэлэлцээд дараах дүгнэлтүүдийг гаргажээ. ОНМХ нь "олон ургальч үзэл дээр тулгуурласан ба төр засаг нь түүнд батлан даагч болсон тохиолдолд" л олон түмэн мэдээлэл хүртэх эрхээ эдэлнэ (38-р заалт). Харин "олон нийтийн монополь байсан цагт" ОНМХ-ээр дамжуулан хүмүүс санаа бодлоо илэрхийлэх боломж бүрмөсөн хаагддаг учраас олон нийтийн монополийг хүлээж авах боломжгүй гэж үзжээ.

Шүүхийн гаргасан өөр нэг чухал шийдвэр бол төр засаг ОНМХ-ийн байгууллагын үйл ажиллагаанд хязгаар тогтоох биш харин түүнийг хөгжүүлэхэд ялангуяа төрөл хэлбэр, шинэ хэв маягийг бий болгоход анхаарч, тус дэмжлэг үзүүлэх төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох зарчмыг хүлээж авах боломжгүй гэсэн заалт юм. Нөгөө талаар ОНМХ хөгжих эдийн засгийн таатай нөхцлийг төр засаг бүрдүүлэх үүрэгтэй гэж үзжээ. Энэ бол сэтгүүл зүйн бие даасан байдлыг хангах үнэхээр чухал заалт мөн.

Өнөөдөр манай оронд үндэсний радио, телевиз, мэдээллийн агентлаг төр засгийн мэдэлд байгаа нь цөөхөн хэдэн мэдээллийн хэрэгслийг эдийн засгийн хувьд ивээн тэтгэж, монополь эрх эдлэх боломжийг бүрдүүлж байна. Мөн манайд шинээр гарах ХМХ-ийг ХЗДХЯ-нд заавал бүртгүүлж, албан ёсны

зөвшөөрөл авдаг хатуу журам байгаа нь мэдээллийн хэрэгслийн бие даасан байдлыг хязгаарлаж байгаа хяналтын нэг хэлбэр юм. Нөгөө талаар томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төрийн мэдэлд байгаа нь өрсөлдөх чадвар бүхий шинэ мэдээллийн хэрэгсэл гарч ирэх боломжийг хязгаарлаж, гарааны ижил нөхцөлд үйл ажиллагаагаа эхлэх боломжгүй болгож байна. Мөн бусад жижиг мэдээллийн хэрэгслүүд реклам нийтэлж, ашиг олох боломжгүй гэсэн үг. Энэ бүхэн нь Европын шүүхийн төр, засаг ХМХ-үүдийн төрөл хэлбэрүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх ёстой гэсэн заалтыг зөрчиж байгаа хэрэг юм. Энэ нь олон түмэн өргөн хүрээний хэрэгцээтэй мэдээллийг хүлээж авах боломжийг хязгаарлаж байгаагийн хамт ил тод байх, олон ургальч үзлийн индэр болох, бие даасан чөлөөт хэвлэлийн гол зарчим зөрчигдөж байгаагийн илрэл мөн. Ийм нөхцөлд чөлөөт хэвлэл, тэр тусмаа эрэн сурвалжлах сэтгүүл зүй жинхэнэ утгаараа хөгжих боломжгүй юм.

Мэдээллийн эрх чөлөөг хамгийн үнэтэй, хамгийн чухал эрх гэж үздэг. Тиймээс 1946 онд болсон НҮБ-ын Ерөнхий ассамблейн анхдугаар чуулганы баталсан 59-р тогтоолд "Мэдээллийн эрх чөлөө бол хүний язгуур эрх бөгөөд ... НҮБ-аас бүх төрлийн эрх чөлөөг хэмжих үндсэн хэмжүүр мөн"³ гэж онцгойлон тэмдэглэжээ.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хувьд мэдээллийн эрх чөлөө бол түүний оршин тогтнох боломж, амин сүнс нь юм. Ер нь мэдээллийг сэтгүүлчийн хамгийн үнэтэй арилжааны бүтээгдэхүүн гэж үздэг нь үүнтэй холбоотой. Мэдээллийн эрх чөлөөний тогтолцоо байгаа нөхцөлд л авилгалыг илчилж, нийгмийн бусад нуугдмал ноцтой асуудлуудыг илрүүлж чадна.

Мэдээллийн эрх чөлөө өөртөө хэд хэдэн хүчин зүйлийг агуулдаг бөгөөд тэдгээрийн дотроос хамгийн чухал нь төр засгийн мэдээллийг чөлөөтэй олох боломж, нууцын тухай хууль, шүгэлдэгчийг хамгаалах, сэтгүүлчийн олж авсан мэдээллийн эх сурвалжийн нууцлал зэрэг асуудлууд юм. Хэрэв сэтгүүлч авилгал, эсвэл бусад ноцтой хэргүүдийг илрүүлж чадна гэж үзэж байгаа бол төр засгийн мэдээллийг авч чадах боломжоор хангагдсан байх хэрэгтэй.

Дэлхий дахины олон оронд төр засгийн мэдээллийг олж авах эрх хуульчлагдсан байдаг ч энэхүү эрх нь бусад эрх зүйн акт, тухайлбал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр баталгаажуулсан учраас үр өгөөж нь муу байдаг ажээ. Тухайлбал, манай орныг хэлж болно. Хэвлэлийн эрх чөлөөг тунхагласан жижиг хуулиас өөр ХМХ-ийн үйл ажиллагааг зохицуулсан ямар ч хууль эрх зүйн акт байхгүй. Өнөөдөр сэтгүүлчдээс мэдээллийн эх сурвалжид нэвтрэх боломж хаалттай, олсон мэдээллийн эх сурвалжийн нууцыг хадгалж, хэлэхгүй байхыг баталгаажуулсан хууль эрхийн акт алга байна.

Ардчилал хөгжсөн, хүний эрхийг хүндэтгэдэг, хэвлэлийн эрх чөлөөг дээдэлдэг Америк зэрэг орон FIA (Freedom of Information Act), Бамбай хууль

³ Мендель Т. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба эрэн сурвалжлах сэтгүүл зүй (лекц). МХХ. 1998.

(Shield Law) мэтийг гаргаж, тэдгээрт олон түмний хүссэн мэдээллийн эх сурвалжид нэвтэрч, хэрэгцээт мэдээ тоо баримтыг сэтгүүлчид олж авах гэхэд нь аль нэг албан тушаалын зөвтгөх үндэслэлгүйгээр татгалзах буюу хориг саад тавих ёсгүйг хуульчлан зааж өгсөн байдаг. Мөн АНУ-д дээрх холбооны улсын хэмжээний мөрддөг гол хуулиудыг үндэслэн муж улс болгон ХМХ-тэй холбоотой хууль боловсруулж гаргасан юм.

"Шүүх, хуулийн байгууллагаас мэдээлэл олж авах тухай", "Мэдээллийн эх сурвалжийг нууцлах тухай хууль" 33 муж улсад бий. Мөн "Төр засгийн үйл ажиллагааг нээлттэй байлгах тухай хууль" орон даяар үйлчилдэг зэргийг бодвол АНУ-д чөлөөт хэвлэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих боломж ямар төвшинд байгаа нь тодорхой юм. Үүний үр дүнд энэ оронд нээлттэй мэдээллийн сан бий болж, хүссэн хүн бүхэн эндээс шаардлагатай мэдээлэл олж авах боломжтой ажээ.

Манайд ийм хууль эрх зүйн акт, боломж байхгүй байгаа нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд ихээхэн саад бэрхшээл учруулж байна. Тухайлбал, Казиногийн гэсэн тодотголтой хээл хахууль, коррупцийн хэргийг илчилж, таслан шийдвэрлэх явцад эрэн сурвалжлах сэтгүүл зүй манайд ямар төвшинд байгаа нь тод харагдсан. Коррупцийг яаж илрүүлдэг, хэрхэн тогтоодог, юу гэж бичдэг, яаж мэдээлдэг талаар суурь ойлголт, үндсэн мэдлэггүйгээс сэтгүүлчид чиг баримжаа муутай, хамаа намаагүй хадуурсан тохиолдол цөөнгүй гарсан. Сэтгүүлчдийн нэг хэсэг нь үндэслэл, баталгаа нотолгоо сайтай юм ярьж байхад нөгөө хэсэг нь эрс ондоо зүйл бичиж, олон түмнийг төөрөгдүүлж байсан. Заримдаа сэтгүүлчдийн бие даасан байдал алдагдаж, сэтгүүл зүйн тэнцвэрт байдлыг хадгалах зарчим ихээхэн хэмжээгээр зөрчигдөж байсныг хэлэх хэрэгтэй.

Энэ бүхэн нь манайд эрэн сурвалжлах сэтгүүл зүй эхлэл төдий байна, түүнийг хөгжүүлэхийн төлөө маш их юм хийх шаардлагатай байгааг харуулж байна. Ингэхийн тулд юуны өмнө чөлөөт хэвлэл жинхэнэ утгаараа хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх хууль эрхийн актуудыг боловсруулан гаргах шаардлагатай юм. Үүнд:

а. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай олон асуудлыг иж бүрэн хөндсөн томоохон хууль гаргах шаардлагатай байна. Үүнийг "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль"-д өөрчлөлт оруулах төдийхнөөр шийдвэрлэх боломжгүй юм. Энд мэдээллийн эх сурвалжид саадгүй нэвтрэх, эх сурвалжийг нууцлах, мэдээлэл олж авахад хориг саад тавих ёсгүйг хуульчлан зааж өгөх хэрэгтэй.

б. Зарим хуулийн заалтуудыг эргэж харж, өөрчлөх, боловсронгуй болгох шаардлага бий. Учир нь манай Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжуудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хаасан, боосон, замыг нь тасалсан заалтууд маш их байдаг. Тэд нуугдмал юмыг олон түмэнд ил гаргаж,

мэдээллийг бодит утгаар нь хүргэх эрэн сурвалжлах сэтгүүл, зүйн зорилгод зөрчилдөж байна.

в. Аливаа орны Нууцын тухай хууль нь маш өндөр төвшинд боловсруулагдсан, хууль зүйд дээд зэргээр нийцсэн байх шаардлагатайгаас гадна түүний заалтуудыг маш тодорхой боловсруулахын сацуу хууль зүйд заасан сонирхлыг хамгаалсан байх ёстой. Нөгөө талаар "Үндэсний аюулгүй байдал, санаа бодлоо илэрхийлэх, мэдээллийг олж авах эрх чөлөөний тухай" Иоханнесбургийн тунхаглалын (1995 он) заалтуудад нийцсэн байх шаардлагатай. Учир нь уг тунхаглалын 15-р заалтад "задруулсан мэдээлэл нь (1) үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг хөсөрдүүлээгүй буюу хөсөрдүүлэхгүй байх, (2) мэдээллийг задруулснаас үүдэх хор хохирлоос олон нийт уг мэдээллийг олж мэдсэн зүйлийн ач холбогдол нь илүү байсан тохиолдолд үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл задруулсны төлөө ял шийтгэл хүлээхгүй"⁴ гэж заасан байдаг.

г. Сэтгүүлчдийн болон шүүхийн байгууллагын хамтын ажиллагаа маш чухал ач холбогдолтой. "Дөрөв дэх засаглал" Шүүх засаглалын хоорондох хамтын үйл ажиллагаа нийгмийн бузар булай, шударга бус зүйлүүдийг илчилж, оновчтой зөв шийдэж, нийгэмд эрүүл саруул уур амьсгал бий болгох, иргэдэд нийгэмдээ, засаг төрдөө, сэтгүүлчдэд, шүүх засаглалд итгэх итгэлийг бий болгох нь чухал юм. Үүнд манай сэтгүүлчдийн байгууллагууд ихээхэн анхаарч ажиллах нь чухал байна.

д. Сэтгүүлчдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Сэтгүүлч өөрийгөө хамгаалах, буруу зөрүү алхам хийхгүй байх, аливаа асуудалд нухацтай, ул суурьтай хандах, тодорхой үр дүнд хүрэхэд хуулийн мэдлэг ус агаар шиг хэрэгтэй. Тиймээс эрэн сурвалжагч мэргэжлийн сэтгүүлч байхаас гадна хуульч байх ёстой. Үүнд ОНМХ-ийн редакци болгон, сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд, сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиуд онцгой анхаарах шаардлагатай юм.

⁴ Мөн тэнд.